



**МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/432

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд зохион байгуулсан "Замын хөдөлгөөний цагаан толгой 2022" улсын аварга шалгаруулах тэмцээнд аймгаа төлөөлөн амжилттай оролцсон баг хамт олны үйл ажиллагааны зардалд зориулан 1,400,000 төгрөгийн дэмжлэгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2.Зардалд зарцуулагдах 1,400,000 төгрөг (нэг сая дөрвөн зуун мянга)-ийг 2022 онд хэрэгжүүлэх аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний 4.6 дахь Хууль, эрх зүйн салбарын дэд хөтөлбөрүүд "Тайван амгалан Ховдчууд" хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
07 дугаар сарын 05-ны өдрийн
А/432 дугаар захирамжийн
Хавсралт

“ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЦАГААН ТОЛГОЙ 2022” УЛСЫН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Оролцогчид	Тоо хэмжээ	Нэг хүний зардал	Нийт зардал
1	Багш	4	92000	368000
2	Эцэг эх	10	92000	920000
3	Хүүхэд	8	14000	112000
Нийт дүн				1400000

-oOo-